



МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

АКТ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IY байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.03.20 № 02/21 ХАТ-САГ/2013/01-СМА-ТЧ

Орлого төвлөрүүлэх тухай

Засгийн газрын нөөц сангийн 2012 оны санхүүгийн тайланд аудит хийх явцад Засгийн газрын тогтоолын хэмнэлтийн 380,173,421.01 төгрөгийг Төсвийн тогтворжуулалтын санд төвлөрүүлээгүй нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 9.2-д "Төсвийн тогтворжуулалтын санг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ", 9.2.3-д "Засгийн газрын нөөц сангийн болон эрсдэлийн сангийн тухайн төсвийн жилийн зарцуулагдаагүй чөлөөт эх үүсвэр" гэж заасантай нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т "...аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих ...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 2.1.1-т "төлбөл зохих төсвийн орлогыг дутуу төвлөрүүлсэн болон төвлөрүүлээгүй"-д төлбөрийн акт тогтооно гэж заасныг үндэслэн ТОГТООХ нь:

1. Засгийн газрын тогтоолын хэмнэлтийн 380,173,421.01 төгрөгийг 2013 оны 5 дугаар сарын 30-ны дотор Монгол банкин дахь Тогтворжуулалтын сангийн 3402024 тоот дансанд татан төвлөрүүлэх
2. Дээрх хөрөнгийг төвлөрүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2013 оны 6 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Сангийн яамны Төрийн сангийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Тавинжил, Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Ц.Ариунсанаа нарт хариуцуулав.

АКТЫГ

ТОГТООСОН:

Үндэсний аудитын газрын  
Ахлах аудитор

Ч.Болд


ЗӨВШӨӨРСӨН:

Сангийн яамны Төрийн сангийн  
даргын үүргийн түр орлон  
гүйцэтгэгч

Ч.Тавинжил

Санхүүжилт, тайлан бүртгэлийн  
хэлтсийн дарга

Ц.Ариунсанаа



070063